

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 8 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2018 оны зургаадугаар сарын 18-ны өдрийн 10 цаг 46 минутад эхэлж, 15 цаг 38 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 58 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	<p>Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай</p> <p>-Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний ажлын байранд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай</p> <p>-Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Пүрэвийн Энхбаатарыг, Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 80 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Ганбаатарын Уугантуяаг тус тус нэр дэвшүүлж, шийдвэр, шалгалтын материалыг холбгдох байгууллагын удирдлагад хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>
2	<p>Говь-Угтаал сумын ИТХ-ын нарийн бичгийн даргыг төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулах тухай</p>	<p>Төрийн албанд олон жил идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж, орон нутагт төр засгийн бодлого шийдвэр, төрийн албаны шинэтгэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, үр дүн гаргаж байгаа Говь-Угтаал сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Думбаагийн Жаргалмааг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахыг дэмжиж, шагналын материалыг журмын дагуу бүрдүүлж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>
3	<p>Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаа”-нд хийсэн нийцлийн аудитын дүнгийн тухай</p>	<p>Төрийн 59 албан хаагчид төрийн жинхэнэ албаны зэрэг дэв олгосон “Зарим албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг олгох тухай” аймгийн тус салбар зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 6 дугаар тогтоол нь Улсын Их Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 14-ны 29 дүгээр тогтоолын 4,5 дахь заалтуудыг зөрчиж, албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн нь хууль бус захиргааны акт болсон тул 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгож, шийдвэрийг Аймгийн Засаг даргад уламжлахаар шийдвэрлэв.</p> <p>Төрийн захиргааны албан тушаалд Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг зөрчсөн томилгооны зөрчлийг арилгаагүй болон нэмж зөрчилтэй томилгоо гаргасан Аудитын үнэлгээнд дурьдагдсан удирдах ажилтнуудад Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.9-ийн 2 дахь заалт, Дундговь аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 оны 06 сарын 05-ны 01/103 ДУА-2018-01-НА тоот албан шаардлагыг тус тус үндэслэн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй хууль, журам зөрчин ажиллаж байгаа тул сахилгын шийтгэл ногдуулах саналыг дээд шатны удирдлагад хүргүүлэхээр болов.</p>
4	<p>Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ</p>	<p>Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын дэс түшмэлийн 8, туслах түшмэлийн 12 нийт 20</p>

	албан тушаалын сул орон тоог нөөцийн зард зарлуулах тухай	сул орон тоог нөөцийн зард зарлуулахаар шийдвэрлэж, холбогдох материалыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр болов.
--	---	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ